



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/519

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Батлан хамгаалах тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 17 дугаар зүйлийн 17.1.1, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны мн/114 дүгээр тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2021 оны н/131 дүгээр тушаал, аймгийн Онцгой комиссын 2021 оны 82 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2021 оны 2 дугаар ээлжийн цэрэг татах үйл ажиллагааг 2021 оны 10 дугаар сарын 04-17-ны өдрүүдэд зохион байгуулахтай холбогдуулан ковид-19 вирусийн халдварын тархалтаас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай түргэвчилсэн тест 400 ширхэг 4 800 000 төгрөг /дөрвөн сая найман зуун мянга/, нэг удаагийн амны хаалт 800 ширхэг 160 000 төгрөг /нэг зуун жаран мянга/, гар ариутгагч 40 ширхэг 480 000 төгрөг /дөрвөн зуун наян мянга/, нийт 5 440 000 төгрөг /таван сая дөрвөн зуун дөчин мянга/-ийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

2. Ковид-19 вирусийн тархалтаас урьдчилан сэргийлэх, цэрэг татлагын байранд ариутгал халдваргүйжүүлэлт хийх, зурагт хуудас, зөвлөмж байрлуулах, хүн хоорондын зай бариулж, халдвар хамгааллын дэглэм чанд сахиулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга /хурандаа Б.Ганхуяг/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
09 дүгээр сарын 29-ний өдрийн
А/519 дүгээр захирамжийн
хавсралт

ШААРДАГДАХ МАТЕРИАЛ ХЭРЭГСЛИЙН ТООЦОО

Д/д	Нэр, төрөл	Тоо хэмжээ /Ширхэг/	Үнэ /Төгрөг/	Нийт үнэ /Төгрөг/
1	Түргэвчилсэн оношлуур	400	12000	4 800 000
2	Амны хаалт /нэг удаагийн/	800	200	160 000
3	Гар ариутгагч /санитол/	40	12000	480 000
4	Бүгд	5 440 000 төгрөг		

-оОо-